



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1992 оны 9 дүгээр  
сарын II-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар  
хот

Нийслэл, дүргийн Засаг даргын  
Тамгын газрын бүтцийг тогтоох  
тухай

Монгол улсын Үндсэн хуулийн жаран нэгдүгээр зүйлийн 4, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хорин наймдугаар зүйлийн I, 3 дугаар заалтыг үндэслэхийн хамт нийслэлийн эрх зүйн үндсийг цаашид хуулиар жич тогтоохыг харгалзан Монгол улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Нийслэлийн удирдлагыг Засаг даргаас гадна Засаг даргын орлогч 4, Тамгын газрын дарга бөгөөд Засаг захиргааны хэлтсийн дарга I байхаар тогтоосугай.

2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг дор дурдсан хэлтэс, тасагтай байхаар тогтоосугай:

- а/засаг захиргааны хэлтэс;
- б/санхүүгийн хэлтэс /хяналтын тасагтай/;
- в/цэрэг, иргэний хамгаалалтын хэлтэс;
- г/статистик, мэдээллийн хэлтэс /тооцоолох төвтэй/;
- д/нийгэм, эдийн засгийн бодлогын хэлтэс;
- е/үйлцвэрлэл, үйлчилгээний хэлтэс;
- ж/хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс;
- з/хянан байцаах хэлтэс;
- и/орон сууц хуваарилалтын тасаг.

3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын сарын цалингийн санг 240,5 мянган төгрөгөөс хэтрүүлэхгүй байхаар тогтоосугай.

4. Нийслэлийн Засаг даргын дэргэд дор дурдсан газар, хэлтэс, алба байхаар тогтоосугай:

- а/хот байгуулалт, төлөвлөлтийн газар;

2.

б/барилга, хөрөнгө оруулалтын газар;  
 в/цагдаагийн газар;  
 г/байгаль орчны газар;  
 д/хот тохижуулах газар;  
 е/хүнс, хөдөө аж ахуйн газар;  
 ж/шинжлэх ухаан, боловсролын газар;  
 з/эргүүл мэндийн газар;  
 и/соёл, олон түмний ажлын хэлтэс;  
 к/залуучууд, спортын хороо;  
 л/хууль зүйн газар;  
 м/өмчийн газар;  
 н/татварын алба.

5. Нийслэлийн дүргийн удирдлагыг дүргийн Засаг даргаас гадна Засаг даргын орлогч I, Тамгын газрын дарга бөгөөд Засаг захиргааны хэлтсийн дарга I байхаар тогтоосугай.

6. Нийслэлийн Хан-уул, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгино, Налайх, Багануур дүргийн Засаг даргын Тамгын газар нь дор дурдсан хэлтэс, тасагтай байхаар тогтоосугай:

а/засаг захиргааны хэлтэс;  
 б/үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс;  
 в/санхүүгийн хэлтэс;  
 г/цэрэг, иргэний хамгаалалтын хэлтэс;  
 д/хянан байцаах хэлтэс;  
 е/хүн амын бодлого, хөдөлмөрийн хэлтэс;  
 ж/статистик мэдээллийн тасаг.

7. Нийслэлийн Гачуурт, Жаргалант, Багахангай, Туул дүрэг нь Засаг дарга, Тамгын газрын дарга, ажилтнуудтай байхаар тогтоосугай.

8. Нийслэлийн дүргүүдийн Засаг даргын Тамгын газрын сарын цалингийн санг нийтэд нь 1373,6 мянган төгрөгөөс хэтрүүлэхгүй байхаар тогтоосугай.

## 3.

9. Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь тухайн шатныхаа хуралд үйлчилж байхаар тогтоосугай.

10. Хорооны Засаг даргын ажлын албыг зохих журмын дагуу зохион байгуулахыг нийслэлийн Засаг даргад даалгасугай.

11. Энэ тогтоолд заасан бүтцийн дагуу нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон нийслэлийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадны орон тоо, цалин, ажиллах журмыг тогтоож мөрдүүлэхийг нийслэлийн Засаг даргад зөвшөөрсүгэй.

12. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан хавсралтад дурдсан Сайд нарын Зөвлөлийн болон Засгийн газрын тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол улсын Ерөнхий  
сайдын орлогч

Ч. ПУРЭВДОРЖ

